



Ховд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 04 дүгээр сарын
03-ны өдрийн 12 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт

АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл /цаашид "зөвлөл" гэх/ нь "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" Монгол улсын хууль, бусад хууль тогтоомжид зааснаар аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Зөвлөл нь үйл ажиллагаандаа Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг удирдлага болгоно. Зөвлөлийн ажиллах журам түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын Тэргүүлэгчид шийдвэрлэнэ.

3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд олгох урамшууллыг тогтооно.

4. Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдийн төлөөлөгч, эрдэмтэдийг оролцуулан ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

5. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан мөн. Зөвлөл нь улирал тутам хуралдана. Зөвлөлийн гишүүдийн олонхи нь хуралдаанд оролцсон бол хүчинтэйд тооцно. Хуралдаанаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүн, зөвлөлийн жилийн ажлын төлөвлөгөө, тайлан, нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажил, Зөвлөлөөс хийсэн шалгалтын дүн зэрэг шаардлагатай асуудлыг хэлэлцэнэ.

6.Зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэл, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс зөвлөмж гаргах бөгөөд зөвлөмжинд Зөвлөлийн дарга, тэмдэглэлд нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, зөвлөмжийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнгийн тухай тогтоосон хугацаанд хариу мэдэгдэх үүрэгтэй.

7.Зөвлөлийн нарийн бичгийн дарга аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд ажиллана.

8.Зөвлөл нь албан бичгийн хэвлэмэл хуудастай, банкинд харилцах данстай байна. Албан ажлын хэрэгцээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тамгыг хэрэглэнэ.

9.Зөвлөлийн дэд дарга, нарийн бичгийн дарга, гишүүд нь Зөвлөлийн даргын гарын үсэг бүхий үнэмлэхтэй байна.

10.Зөвлөл нь үйл ажиллагаагаа аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, дээд шатны Зөвлөлд хагас жил тутамд тайлагнаж байна.

Хоёр. Зөвлөлийн эрх:

1.Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газар, хэлтэс, тасаг, агетлагууд, байгууллага, аж ахуйн нэгжээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиосон ажлын тайланг гаргуулан авах.

2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомж, Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, зөвлөмжийн биелэлтийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид өмчийн харъяалал харгалзахгүйгээр шалгах, тэдгээрийн удирдах ажилтны илтгэл, сонсголыг Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж чиглэл, зөвлөмж өгөх.

3.Нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хуваарилах, зарцуулах.

4.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгийн зарцуулалтанд хяналт тавьж, тайланг хагас, бүтэн жилээр гаргуулан, дүгнэлт хийх, шаардлагатай гэж үзвэл гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн зарим хэсгийг аймгийн хэмжээний эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдлыг хөнгөрүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ, сургалт сурталчилгаанд зарцуулах.

5.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд мэргэжлийн хүмүүсийг үндсэн байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр татан оролцуулах.

6.Эрх хэмжээний асуудлаар орон нутгийн чанартай хурал, зөвлөгөөн, семинар зохион байгуулах.

7.Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журам хангах ажилд идэвхтэй оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтныг шагнаж урамшуулах, шагнаж урамшуулахаар холбогдох байгууллагад уламжлах.

8.Зөвлөлийн хуралдааны тэмдэглэл, зөвлөмжийг биелүүлээгүй, хугацаа хожимдуулсан албан тушаалтны талаар холбогдох байгууллагад нь албан ёсоор танилцуулж хариу авах.

9.Хууль, тогтоомж сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоохтой холбогдсон мэдээлэл, сурталчилгааны материалыг хэвлэл мэдээллийн байгууллагад өгч, хэвлэн нийтэлж, нэвтрүүлэх, самбар, үзэсгэлэн гаргах ажлыг зохион байгуулах.

2.Зөвлөлийн гишүүний эрх: Зөвлөлийн гишүүн дараах эрхийг хэрэгжүүлнэ:

1.Зөвлөлийн хуралдаанаар асуудал хэлэлцүүлэх, санал оруулах.

2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхтэй холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийг нутаг дэвсгэрийн бүхий л хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжид шалган танилцаж, заавар, зөвлөмж өгөх.

3.Сум, багийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлыг шалган туслах, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.

4.Зөвлөлийн гишүүн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үүргээ биелүүлэх үедээ зөвлөмж, гаргасан шийдвэрийн биелэлтэнд хяналт тавьж өмчийн хэлбэр, харъяалал харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгжийн албан байранд тогтоосон журмын дагуу нэвтэрч холбогдох мэдээ, баримт, материал гаргуулан авах.

3.Зөвлөлийн даргын эрх: Зөвлөлийн дарга нь Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулинд заасан эрх үүргээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1.Зөвлөлийг тэргүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, хуралдааныг товлох, удирдах.

2.Зөвлөлийг боловсон хүчин, аж ахуйн хувьд бэхжүүлж, төсөв хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах.

3.Зөвлөлийн гишүүд, иргэд, хамт олонд шагнал урамшил олгох, ажлын сайн арга, туршлагыг нийтийн хүртээл болгох.

4.Зөвлөлийн шийдвэрийн биелэлтэнд хяналт тавьж холбогдох асуудлаар захирамж, албан даалгавар гаргах.

5.Хууль тогтоомжид заасан бусад эрх.

4. Зөвлөлийн нарийн бичгийн даргын эрх: Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн гишүүний бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1.Зөвлөлийн хуралдаан, түүний шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах.

2.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шуурхай зохицуулж байх.

3.Сумын зөвлөлийг байнгын удирдлагаар хангаж, зохион байгуулалт, арга зүйн туслалцаа үзүүлэх.

4.Зөвлөлийн даргаас өгсөн үүрэг, хариуцуулсан ажлыг хэрэгжүүлэх.

5.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардлын төсөв, санхүүжилтийн талаар санал боловсруулах.

Гурав. Зөвлөлийн үүрэг.

1.Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах сумын зөвлөл, төрийн өмчийн болон бүхий л хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар зохиож байгаа ажлыг аймгийн хэмжээнд уялдуулан зохицуулах.

2.Нутгийн захиргааны болон нийгмийн аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын удирдах ажилтан, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн зөвлөлгөөн зохион байгуулж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлт, үр дүнг хэлэлцэн цаашид авах арга хэмжээг хамтран төлөвлөх.

3.Иргэдийн амь нас, эрүүл мэнд, бусдын өмч хөрөнгөнд халдах, хулгайлах, архидан согтуурах, танхайрах, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх болон авилгын эсрэг арга хэмжээг хүчтэй болгоход бүх нийтийн хүч анхаарлыг чиглүүлэх.

4.Дангаараа буюу холбогдох байгууллагуудтай хамтран аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажлын тухай илтгэл, мэдээлэл, авах арга хэмжээний төсөл, хөтөлбөр боловсруулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх.

5.Улсын Их хурал, Засгийн газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын баталсан нийгмийн дэг журам хангах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөний биелэлтэнд хяналт тавих, биелэлтийг хангуулах ажлыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах.

6.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам хангах, сахилга зохион байгуулалтыг сайжруулах талаар иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс гаргасан

санал, хүсэлтийг судлан түүний мөрөөр асуудал боловсруулан хэрэгжилтийг зохион байгуулах.

7.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд иргэд, төрийн бус байгууллагын үүсэл санаачлагыг дэмжин тэднийг энэ ажилд өргөнөөр татан оролцуулах, идэвхижүүлэх, туслалцаа үзүүлэх.

8.Гэмт хэргийн байдал, түүний шалтгаан нөхцлийн талаар статистик мэдээг авч нэгтгэн судлах, дүгнэлт хийх.

9.Гэмт хэрэг, хэв журмын нөхцөл байдалд хяналт шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг судлах, арилгах, таслан зогсоох арга хэмжээний чиглэлийг тогтоох.

10.Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар байгууллага, аж ахуйн нэгжээс зохион байгуулж байгаа ажлыг шалган зааварлаж, мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэн удирдлагаар хангаж ажиллах

11.Зөвлөлөөс зохиож буй ажлын явц, үр дүнгийн талаар олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулах

12.Зөвлөл нь дээд шатны зөвлөлийн шийдвэрийг биелүүлж ажиллана.

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагааны санхүүжилт

1. Зөвлөлийн дэргэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг аймгийн хэмжээнд зохицуулахад зарцуулах зориулалт бүхий “сан”-тай байж болно. Сангийн мөнгөн хөрөнгө нь төсвөөс баталж өгсөн хөрөнгө, зөвшөөрөгдсөн хүү торгуулийн орлогын 40 хувьтай тэнцэх орлого болон дотоод, гадаадын байгууллага, иргэдийн өгсөн хандив, тусламж, төслийн хөрөнгө, бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

2. Зөвлөл үйл ажиллагаа явуулахад шаардагдах төсөв, хөрөнгийг аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсөвт жил бүр бие даалган төсөвлөж, санхүүжүүлнэ. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн ерөнхий менежер эрхлэн зарцуулна. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар Зөвлөлийг ажлын байраар хангаж, ажлаа хэвийн явуулах бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлж унаагаар үйлчилнэ.

Тав.Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

1. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар толгойлуулсан зөвлөл зохицуулна.

2.Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүрэлдэхүүнийг нутгийн захиргааны болон улсын

байцаагчид, цагдаагийн хэсгийн төлөөлөгч, идэвхитэн сонгуультаан, нутаг дэвсгэрийн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөлтэйгөөр тухайн сумын иргэдийн Нийтийн Хурлын тэргүүлэгчид батална.

3.Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл энэхүү журмыг үндэслэн тухайн нутаг дэвсгэрийн онцлогийг тусгасан журмыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр батлан мөрдөж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулахтай холбогдсон хууль тогтоомж, дээд шатны зөвлөлийн шийдвэрийг биелүүлж ажиллана.

4.Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг тухайн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг Даргын Тамгын Газрын төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ.

Зургаа. Багийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл

1.Багийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийг Багийн иргэдийн Нийтийн Хурлын даргаар толгойлуулсан зөвлөл зохицуулна.

2.Багийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл нь 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд багийн Засаг дарга, идэвхтэн сонгуультаан, төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж малчид, тариаланчид, бизнес эрхлэгчид, иргэдийн төлөөлөлтэйгээр тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаас байгуулна.

3.Багийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь энэхүү журмыг үндэслэн тухайн багийн онцлогийг тусгасан журам боловсруулан багийн иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулан мөрдөж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хангах ажлыг зохицуулахтай холбогдсон хууль тогтоомж, дээд шатны зөвлөлийн шийдвэрийг биелүүлж ажиллана.

4.Багийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардлыг багийн иргэдийн Нийтийн Хурал багийн Засаг даргын төсөвт жил бүр тусган санхүүжүүлнэ.

ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ
ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- | | |
|-----------------------|---|
| Дарга: | - Аймгийн ИТХ-ын дарга |
| Дэд дарга: | - Аймгийн Засаг дарга |
| Нарийн бичгийн дарга: | - ГХУСАЗ салбар зөвлөлийн ажилтан |
| Гишүүд: | - Аймгийн Ерөнхий аудитор /зөвшилцсөнөөр/
- Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга /зөвшилцсөнөөр/
- Аймгийн Прокурор /зөвшилцсөнөөр/
- Өмгөөлөгчдийн холбооны дарга
- Цагдаагийн газрын дарга
- Аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга
- Онцгой байдлын газрын дарга
- Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга
- Боловсрол, соёлын газрын дарга
- Эрүүл мэндийн газрын дарга
- Зэвсэгт хүчний 123-р ангийн захирагч
- Цагдаагийн газрын Олон нийттэй харилцах ахлах байцаагч
- Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга
- “Эко” телевизийн захирал |